



**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021. 04. 29.

№ 01

Улаанбаатар хот

Компанийн санхүүгийн тайлан, түүнд
хийгдсэн хараат бус аудитын
дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт,
Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа
эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд
хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэж баталсугай.

ХУРЛЫН ДАРГА: / Э.БАТБОЛД /





Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021. 04. 29.

№ 02

Улаанбаатар хот

Компанийн үйл ажиллагааны
тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс үйл ажиллагааны талаар гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА: / Э.БАТБОЛД /





Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021.04.29

№ 03

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны үйл ажиллагааны
тайлан, санхүүгийн тайлангийн талаар
ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт,
Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа
эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь**:

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан,
санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ын дүгнэлтийг хангалттай гэж
үзсүгэй.
2. Бизнес төлөвлөгөө, гаргасан зөвлөмжийн гүйцэтгэлд анхаарч ажиллахыг
Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА: / Э.БАТБОЛД /





**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021. 04. 29.

№ 04

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны бизнес
төлөвлөгөөг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн 2021 оны бизнес төлөвлөгөөг баталсугай.
2. Төлөвлөгөөнд дурьдагдсан ажлуудыг чанартай хийж гүйцэтгэх, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал / Ч.Амарсанаа/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА: / Э.БАТБОЛД /





**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021. 04. 29.

№ 05

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
зардлын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг 4,560,000 төгрөгөөр тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА: / Э.БАТБОЛД /





**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021. 04. 29.

№ 06

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дах заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын дүн, тогтоолыг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь**:

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр
 - 1) Данзан ДАЯНБИЛГҮҮН
 - 2) Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ
 - 3) Шараа ШИНЭБАЯР
 - 4) Чулуун АМАРСАНАА
 - 5) Чулуун ЭНХБОЛД
 - 6) Энхболд БАТБОЛД

2. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр
 - 1) Хасаг БАТ-ЭРДЭНЭ
 - 2) Чулуунбаатар ОРГИЛ
 - 3) Жаргалсайхан ЭНХТУЛГА нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА: / Э.БАТБОЛД /





**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021.04.29.

№ 07

Улаанбаатар хот

Компанийн ногдол ашиг тараах тухай

“Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас
ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн Ногдол ашиг тараах талаар гаргасан шийдвэрийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА: / Э.БАТБОЛД /



“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021.04.29

Замын-Үүд сум

“Э-Транс ложистикс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 сарын 29-ны өдөр цахимаар 10 цагаас эхлэв.

Хурлын дэгийг Хурал зохион байгуулах комиссын дарга С.Ганбат уншиж танилцуулан дэгийн дагуу тооллогын комиссын ирцийн тогтоол танилцуулснаар хурлыг эхэллээ.

“Э-Транс ложистикс” ХК нь нийт саналын эрх бүхий 46,200,000 ширхэг хувьцаатай. Нийт саналын эрх бүхий хувьцааны 89,58% буюу 41,385,465 ширхэг хувьцаа эзэмшиж буй 18 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэйгээр хуралдсан.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан
3. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах
4. Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөг батлах
5. ТУЗ-ийн 2021 оны цалин урамшууллын төсөв батлах
6. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
7. Ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

Компанийн ерөнхий нягтлан бодогч Э.Ариунтуяа:

Компанийн 2020 оны санхүүгийн тайлан түүнд хийгдсэн аудитын дүгнэлтийг таницуулав.

Компанийн Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

Хурлаар хэлэлцэх асуудлуудын дагуу компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, компанийн өнөөгийн нөхцөл байдлыг танилцуулав.

Компанийн ТУЗ-ийн дарга Э.Батболд:

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг уншиж танилцуулав.

Компанийн менежер Х.Батхишиг:

Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөг танилцуулав.

Компанийн ТУЗ-ын дарга Э.Батболд:

Хэлэлцэх асуудлын дагуу ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох, ТУЗ-ийн 2021 оны цалин урамшууллын төсөв батлах, Ногдол ашиг тараах талаар гаргасан шийдвэрийг тус тус танилцуулав.

Хэлэлцсэн асуудалуудтай холбогдуулж асуулт асуух хувьцаа эзэмшигч байхгүй байсан тул асуулт хариулт, санал хэлэх үйл ажиллагаа дуусч санал хураах үйл ажиллагаа эхлэв.

Тооллогын комисс хурлын шийдвэрийг танилцуулав.

Санал хураалтаар нийт хувьцааны 99,98% буюу 41,384,084 ширхэг хувьцаа эзэмшиж буй 6 хувьцаа эзэмшигч саналын хуудас бөглөн өгсөн.

Хэлэлцэх асуудал 1:

Саналын хуудсаар 2020 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 99,98% буюу 41,384,084 ширхэг хувьцаа эзэмшиж буй 6 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00 % татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
41,384,084	100%	0	0.00%	0	0.00%

Хэлэлцэх асуудал 2:

Саналын хуудсаар 2020 оны үйл ажилллагааны тайланг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу буюу 99,98% буюу 41,384,084 ширхэг хувьцаа эзэмшиж буй 6 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00 % татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
41,384,084	100%	0	0.00%	0	0.00%

Хэлэлцэх асуудал 3:

Саналын хуудсаар Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 99,98% буюу 41,384,084 ширхэг хувьцаа эзэмшиж буй 6 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00 % татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
41,384,084	100%	0	0.00%	0	0.00%

Хэлэлцэх асуудал 4:

Саналын хуудсаар Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 99,98% буюу 41,384,084 ширхэг хувьцаа эзэмшиж буй 6 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00 % татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
41,384,084	100%	0	0.00%	0	0.00%

Хэлэлцэх асуудал 5:

Саналын хуудсаар ТУЗ-ын 2021 оны цалин урамшууллын төсөв батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 41,384,084 ширхэг хувьцаа эзэмшиж буй 6 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00 % татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
41,384,084	100%	0	0.00%	0	0.00%

Хэлэлцэх асуудал 6:

Саналын хуудсаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 41,384,084 ширхэг хувьцаа эзэмшиж буй 6 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй саналын хуудсаар:

Ердийн гишүүдэд өгсөн санал:

	ТУЗ-ийн гишүүний нэр	ердийн	Саналын хувь	Кумулятив өгсөн саналын тоо	аргаар
1	Чулуун Энхболд		11,17%	41,590,995.00	
2	Чулуун Амарсанаа		11,17%	41,590,995.00	
3	Энхболд Батболд		11,17%	41,590,995.00	
4	Данзан Даянбилгүүн		11,08%	41,250,995.00	
5	Бүрэнмэнд Лхагвадорж		11,05%	41,170,995.00	
6	Шараа Шинэбаяр		11,05%	41,170,995.00	

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

	ТУЗ-ийн гишүүний нэр	хараат бус	Саналын хувь	Кумулятив өгсөн саналын тоо	аргаар
1	Чулуунбаатар Оргил		11,17%	41,598,069.00	
2	Жаргалсайхан Энхтулга		11,17%	41,590,995.00	
3	Хасаг Бат-Эрдэнэ		10,98%	40,903,531.00	
4	Цэнгэл		0,00%	0.00	

тус тус санал авч дараах гишүүд ТУЗ-ийн гишүүнд сонгогдов. Үүнд:

Ердийн гишүүнд:

1. Энхболд Батболд
2. Чулуун Амарсанаа
3. Чулуун Энхболд
4. Данзан Даянбилгүүн
5. Бүрэнмэнд Лхагвадорж
6. Шараа Шинэбаяр

Хараат бус гишүүнд:

1. Чулуунбаатар Оргил
2. Жаргалсайхан Энхтулга
3. Хасаг Бат-Эрдэнэ

Хэлэлцэх асуудал 7:

Саналын хуудсаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөг гаргасан ногдол ашигтай холбоотой шийдвэрийг батлах асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 41,384,084 ширхэг хувьцаа эзэмшиж буй 6 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00 % татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.

11:03 цагт Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолын шийдвэрийг танилцуулан дуусч, хурлын дарга хурлыг хаав.

Хурлын дарга:



/

Э.Батболд /

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



/

С.Ганбат /

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

2021.04.29



Хэлэлцэх асуудал 1. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлт

▪ Санхүүгийн байдлын тайлан

	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1. ХӨРӨНГӨ		
1.1 Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	57,491.2	241,762.3
Дансны авлага	600.0	
Татвар, НДШ - ийн авлага	-	-
Хангамжийн материал	51,621.8	41,362.1
Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	10,200.0	46,170.1
Эргэлтийн хөрөнгийн дүн	119,913.0	330,897.4
1.2 Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	4,556,235.9	4,419,210.2
Биет бус хөрөнгө	546,647.8	476,792.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,102,883.6	4,896,002.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,222,796.6	5,226,900.3
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ		
2.1 Өр төлбөр		
Дансны өглөг	242,416.4	16,958.1
Татварын өр	19,024.3	14,706.5
Урьдчилж олсон орлого	2,100.0	220.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	263,540.7	31,884.6
Урт хугацаат зээл	164,000.0	128,000.0
Урт хугацаат өр төлбөрийн дүн	164,000.0	128,000.0
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	427,540.7	159,884.60
2.2 Эзэмшигчдийн өмч		
Хувийн өмч	4,620,000.0	4,620,000.0
Нэмж төлөгдсөн капитал	154,000.0	154,000.0
Хуримтлагдсан ашиг	(753,602.2)	(481,842.50)
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	774,858.1	774,858.1
Эзэмшигчдийн өмчийн дүн	4,795,255.9	5,067,015.60
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН	5,222,796.6	5,226,900.30

▪ **Орлогын дэлгэрэнгүй тайлан**

Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого	712,587.2	1,021,849.4
Борлуултын өртөг	0.0	0.0
<u>Нийт ашиг, алдагдал</u>	<u>712,587.2</u>	<u>1,021,849.4</u>
Түрээсийн орлого	44,826.3	41,181.8
Хүүгийн орлого	76.8	107.4
Бусад орлого	13,249.9	180,737.0
Ерөнхий ба удирдлагын зардал	893,655.7	926,297.2
Санхүүгийн зардал	32,082.5	27,165.3
Бусад зардал		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (ГАРЗ)	9.3	11.9
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (ГАРЗ)		
Бусад зардал	10,752.3	12,300.0
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(165,741.00)	278,125.00
Орлогын татварын зардал	7.7	6,365.3
Татварын дараах ашиг (алдагдал)	(165,748.70)	271,759.70
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0	0
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(167,748.70)	271,759.70

Орлого / өсөлт бууралт /

д/д	Орлогын нэр	2019 он	2020 он	Зөрүү	Өсөлт/ бууралт
1	Ачилтын орлого	89,620.2	78,103.04	-11,517.1	14.7% буурсан
2	Буултын орлого	1,200.0	0	-1,200	100% буурсан
3	Хадгалалт болон гарах хуудас	490,790.1	943,746.3	452,956.2	92.3% өссөн
4	Түрээсийн орлого	45,772.7	41,818.8	-3,953.9	9.45% буурсан
5	Бусад орлого	264,231.9	180,100.1	-84,131.8	46.7% буурсан

▪ **Өмчийн өөрчлөлтийн тайлан**

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	4,620,000.0		154,000.0		774,858.0	(587,853.50)	4,961,004.5
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						(165,748.70)	(165,748.70)
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	4,620,000.0		154,000.0		774,858.0	(753,602.20)	4,795,255.9
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						271,759.70	271,759.70
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	4,620,000.0	0.0	154,000.0	0.0	774,858.0	(481,842.50)	5,067,015.6

▪ **Богино хугацаат өр төлбөр**

үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
дансны өглөг		
дансны өглөг	242,416.4	16,958.2
дүн	242,416.4	16,958.2
татварын өглөг		
ААНОАТ-ын өр	5.1	2,910.4
ХХОАТ-ын өр	1,729.8	1,709.4
НӨАТ-ын өр	17,289.4	10,086.6
дүн	19,024.3	14,706.4
бусад өглөг		
урьдчилж орсон орлого	2100.0	220.0
ногдол ашгийн өр	-	-
дүн	2100.0	220.0
нийт дүн	263,540.70	31,884.60

▪ **Урт хугацаат өр төлбөр**

үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
урт хугацаат зээл (ХХБ-аас авсан зээл)	164,000.0	128,000.0
бусад урт хугацаат өр төлбөр	0.0	0.0
БҮГД	164,000.0	128,000.0

▪ **Эзэмшигчдийн өмч**

үзүүлэлтүүд	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
хувьцаат капитал	46,200,000	46,200,000
нэмж төлөгдсөн капитал	154,000.0	154,000.0
эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	774,858.1	774,858.1
хуримтлагдсан ашиг	(753,602.20)	(481,842.50)
нийт дүн	4,795,255.9	5,067,015.6



Хэлэлцэх асуудал 2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан

- 2020 онд тус компани нь дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлаас шалтгаалан улс орны эдийн засаг хүндэрч үндсэн үйл ажиллагаа тодорхой хэмжээнд доголдсон боловч үйл ажиллагаагаа зөв төлөвлөж, оновчтой шийдвэрийг цаг тухай бүр аван бусад үйлчилгээг өөрсдийн хүчин чадлын хэмжээнд нэмэгдүүлсний үр дүнд тодорхой хэмжээнд ашигтай ажиллаж чадлаа гэж дүгнэж болно. Үйл ажиллагааны 2020 оны нөхцөл байдлын дараах үзүүлэлтүүдээр гаргасныг танилцуулж байна.




Шилжүүлэн ачилт


Компанийн гол үйлчилгээ болох шилжүүлэн ачилт Замын-Үүд өртөөний үйл ажиллагаанаас шалтгаалан өмнөх жилүүдийнхээс ихээхэн доголдох болсон. Вагоны хангалт, ачаа татах ажлууд удааширнаас тус салбар замаар шилжүүлэн ачилт хийлгэх хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж улам буурсаар байгаа нь цаашид шилжүүлэн ачилтын үйлчилгээг ажлуулахад бэрхшээлтэй эрсдэлтэй нөхцөл байдал үүсэж байна.

Шилжүүлэн ачилт

АЧААНЫ ТӨРӨЛ, АЧИГДСАН САРААР НЬ ХАРЬЦУУЛБАЛ




2019, 2020 ОНЫ АЧИЛТЫГ ХАРЬЦУУЛБАЛ




Шилжүүлэн ачилт

2015-2020 оны шилжүүлэн ачилтын график




Гаалийн хяналтын бус, баталгаат агуулах

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСЭД ХИЙГДСЭН БҮРДҮҮЛЭЛТ



ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСЭД ХИЙГДСЭН ЭКСПОРТЫН БҮРДҮҮЛЭЛТ




Гаалийн хяналтын бүс, баталгаат агуулах

ГХБ-Д НЭВТЭРСЭН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Сар	Гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл		Хяналтын бүс болон агуулахад ачаа бараа хадгалсны хураамж
	Тоо	Хураамж	
1 сар	378	12,280,000	93,334,400
2 сар	204	7,729,091	61,553,980
3 сар	935	9,801,818	53,429,480
4 сар	1288	13,578,182	21,281,916
5 сар	1352	14,515,454	13,436,800
6 сар	1358	16,041,818	19,552,445
7 сар	1449	18,870.0	4,613.2
8 сар	1817	32,145.4	
9 сар	1907	49,357.3	87,227.9
10 сар	1780	51,921.8	173,063.9
11 сар	1328	40,972.8	23,342.2
12 сар	276	7,036.4	87,713.7
Нийт дүн	14,072	274,340.0	669,406.4

- Гаалийн хяналтын бүсэд Замын-Үүд хилийн боомт дахь Авто замын шалган нэвтрүүлэх цэгийн гаалийн хяналтын бүсийн АЗШНЦ-т шалгагдаж байсан төрөл бүийн ачааны гаалийн хяналт шалгалт 2020 оны 02 дугаар сард шилжиж ирснээр тус гаалийн бүсийн ачаалал 2 дахин нэмэгдэж үүнийг дагаад орлого нэмэгдсэн. Мөн харилцагч тээвэр зуучийн компаниуд болон бусад харилцагч нараар дамжуулан гаалийн баталгаат агуулахад удаан хугацаагаар хадгалагдах боломжтой ачаа барааг оруулж ирснээр хадгалалтын орлогыг мөн тодорхой хувиар нэмж чадав.

Гаалийн хяналтын бус, баталгаат агуулах





Хэлэлцэх асуудал 3. 2021 оны бизнес төлөвлөгөө

- Төлөөлөн улирдар зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 19-нд эчнээ хурлаар 2021 оны бизнес төлөвлөгөөг баталсан.

2021 оны бизнес төлөвлөгөө

Эдийн засгийн зорилтот үзүүдэлт	2018	2019	2020	2021
Нийт борлуулалтын орлого	561,253.2	712,587.2	1,021,849.4	1,031,025.4
Нийт зардал	932,709.2	925,738.2	953,463.1	892,760.9
Татварын өмнөх ашиг/алдагдал	(230,490,584.5)	(165,741.0)	278,125.0	138,264.5
Ашиг/ алдагдал	(230,499,775.3)	(165,741.0)	271,759.6	129,547.5

■ Орлогын төлөвлөгөө

Мян.төг	2021 оны борлуулалт, ашгийн төлөвлөгөө
Нийт үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого	1,031,025.4
Ачилтын орлого	/Шилжүүлэн ачилтын орлогыг буурна гэж тооцож байна. 2020 оны зун цементний үйлдвэрүүд зогссон тул Эрээнээс цементний тээвэр нэмэгдсэн энэ онд / 18,600.0
Буултын орлого	/2020 оны байдлаар экспортод гарах ачааны гэрээ хийгдээгүй тул тус үйлчилгээний орлогыг тооцоолоогүй / 0.0
Хадгалалтын орлого	314,000.0
Баталгаат агуулахын орлого	418,600.0
Бусад үйлчилгээний орлого /экспортын ачааны пүү, чингэлэг ачаа, кран карын ачилт бусад ордог Цайны газрын орлого /	225,916.3
Түрээсийн орлого	53,909.1
Хүүний орлого	
Нийт зардал	892,760.9
Ерөнхий ба удирдлагын зардал	874,325.7
Санхүүгийн зардал	18,435.2
Гадаад валютын ханшийн зөрөөний олз/гарз	0.0
Бусад зардал	0.0
Татварын өмнөх ашиг	138,264.5
Татварын зардал /10%/	8,717.0
Татварын дараах ашиг	129,547.5



**Хэлэлцэх асуудал 5. 2020
оны үйл ажиллагаа болон
санхүүгийн тайлангийн
талаар ТУЗ-ийн дүгнэлт**

ТҮЗ-ийн дүгнэлт

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар компанийн 2020 оны бизнес төлөвлөгөө, санхүүгийн тайлангийн талаар хэлэлцэж дараах дүгнэлтийг өгсөнг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

Э-Транс ложисик хувьцаат компанийн хамт олон нь 2020 оны бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааныхаа чиглэл, зорилт зорилгыг биелүүлэхийн тулд цар тахлын хүнд хэцүү үед, удирдлага зохион байгуулалтын зөв оновчтой шийдвэрийг гаргаж, идэвхи зүтгэл гаргаж ажилласны хүчинд 2020 оны санхүүгийн үйл ажиллагааны цэвэр ашиг 271,759.6 төгрөгний ашигтай ажилласан байна. Ийм ч учраас Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлын шийдвэрээр Хувьцаа эзэмшигч нартаа энэ цэвэр ашгийн 85 хувь буюу нэгж хувьцаанд 5 төгрөгөөр 46,200,000 хувьцаанд нийт 231.000.000.00 төгрөгний ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн.

Компанийн үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачих үйл ажиллагаа өмнөх оны мөн үеийн хэмжээнд (565 вагон) байгаа боловч ачилтын төрлөөр авч үзсэн тоон мэдээнээс үзвэл хорио цээрийн үеийн нөхцөл байдалтай уялдаж барилгын зарим ачаа буюу цемент нэлээн их (221 вагон) ачигдаж ачилтын тоо хэмжээг өмнөх үеийнхтэй адил түвшинд аваачсан нь харагдаж байна. Цаашид энэ төрлийн ачаа нэгэнт ачигдахгүй нь тодорхой тул шилжүүлэн ачилтын төрөл, хэмжээг өсгөх тал дээр тодорхой ажил зохион байгуулах шаардлагатай байна.

Цар тахлын улмаас улсын хилийн хорио тавьсантай холбоотойгоор нурмаг ачаа болох жоншны хүдрийг bigbag савалгаатайгаар машинаас машинд шилжүүлэн ачих ажил зогссон боловч цаашид нөхцөл байдал сайжирсан тохиолдолд дээрх ажлыг үргэлжлүүлэх талаар яриа хэлэлцээрийн ажлыг нэн даруй хийж гүйцэтгэх шаардлагатай байгааг гүйцэтгэх удирдлагад зөвлөлөө.

Цаашид гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаагаар үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутагтаа тэргүүлэх байр суурийг хадгалж, үйл ажиллагаагаа жигдрүүлж, нөхцөл байдлаа сайжруулан үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, тухайн хяналтын бүсэд ажиллаж байгаа гааль, мэргэжлийн хяналтын ажилтан нарын итгэлийг хүлээсэн компаниар үйлчлүүлэх, ирж ажиллаж байх хүсэл сонирхолтой компани байхыг зорилгоо болгон ажиллах шаардлага тулгарч байна. Тийм ч учраас хяналтын бүсийн нөхцлийг сайжруулах, ялангуяа хяналт шалгалт хийх нөхцөл бололцоог дээшлүүлэхэд чиглэсэн ажил зохион байгуулахыг үүрэг болгов.

Гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын үйл ажиллагаа, түүгээр үйлчлүүлэгчдийн тоо хэмжээ, үйлчилгээний хураамж жил бүр өсөж цаашид тогтвортой байх хандлагатай байгаа нь компанийн үйл ажиллагааны тайлан мэдээнд дурдагдсан тоо мэдээнээнээс харж болох бөгөөд 2020 оны байдлаар гаалийн хяналтын бүсэд 14,072 тээврийн хэрэгсэл нэвтэрч үйлчилгээний хураамж 274,340.0 төгрөгийг, гаалийн баталгаат агуулахад ачаа бараа хадгалуулсны хураамж 669,406.4 төгрөгийг орлогод авсан нь хяналтын бүсийн үйл ажиллагаа өндөр ачаалалтай сайн ажилласан нь харагдаж байна.

Компанийн дээрх үндсэн үйлчилгээнүүдээс гадна бусад үйлчилгээнүүд нь тухайн бүс нутагт цар тахал, өвчлөл гарсантай холбоотойгоор нэлээн буурсан үзүүлэлттэй байгаа ба дээрх шалтгаан нөхцөл арилсан тохиолдолд эргэж сэргэх боломжтой гэж үзэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагааг тогтвортой, үр ашигтай, ажиллуулахад чиглэсэн урт болон богино хугацааны бизнес төлөвлөгөө боловсруулах талаар үүрэг чиглэл өгөгдсөн боловч зөвхөн 2021 онд хийгдэх үйл ажиллагаатай уялдсан төлөвлөгөөг боловсруулан танилцуулж байгаа нь учир дутагдалтай байна. Иймд компанийн гүйцэтгэх удирдлагын багт маркетинг, менежментийн цогц бодлого боловсруулан, төлөвлөж нэн даруй хийж гүйцэтгэн танилцуулахыг үүрэг болголоо.



**Хэлэлцах асуудал 5. ТУЗ-
ын ердийн болон хараат
бус гишүүнд нэр
дэвшигчид**

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч
Чулууны Энхболдын тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Чулууны Энхболд

Төрсөн он: 1967 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: Э-Транс ХХК-ийн ерөнхий захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Төв аймгийн Зуунмод хотын 10 жилийн сургууль	Бүрэн дунд	1974	1984
2	Ленинградын Төмөр замын дээд сургууль		1984	1989
3	АНУ-д агаарын тээврийн аюултай ачаа тээвэрлэлтийн сургалт		1999	2000

3. Ажлын туршлага

1989-1990 онд УБТЗ-ын өртөө ажилчин

1990-1992 онд УБТЗ-ын Замын –Үүд өртөө орлогч дарга

1992-1994 онд УБТЗ-ын Багануур өртөө орлогч дарга

1992-1997 онд ТУУШИН ХХК ОУ-ын тээвэр зууч, экспортын тээвэрлэлтийн мэргэжилтэн

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч
Чулууны Амарсанаагийн тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Чулууны Амарсанаа

Төрсөн он: 1961 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: Э-Транс Ложистикс ХХК гүйцэтгэх захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1969	1979
2	ЗХУ-ын Свердловск хотын Уулын дээд сургууль		1979	1984
3	БНСЧС улсын Коопщинице мэргэжил дээшлүүлсэн		1989	1990

3. Ажлын туршлага

1984-1985 онд Бугантын алтны үйлдвэрт засварчин, туслах эксваторчин

1985-1991 онд Цагаан дэлийн уурхай, ерөнхий механик

1991-1995 онд Монгол Чехийн хамтарсан үйлдвэр, Ерөнхий инженер дарга

1995-2002 онд Монгол Чехийн хамтарсан үйлдвэрийн харьяа Хавчуугийн алтны уурхай, ерөнхий инженер дарга

2002-2011 онд Э-Транс ХХК, гүйцэтгэх захирал

2011 оноос Э-Транс Ложистикс ХХК гүйцэтгэх захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч
Энхболдын Батболдын тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Энхболдын Батболд
Төрсөн он: 1987 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: Э-Транс ХХК, дэд захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1995	2004
2	Тайваний их сургууль	Эрх зүйч	2008	2014

3. Ажлын туршлага

2014 онд Тайвань дахь худалдаа эдийн засгийн төлөөлөгчийн газарт туслах ажилтан,
2016 оны 04 сараас Баянцемент ХХК, ерөнхий менежер
2018 оны 06 сараас Э-Транс ХХК, дэд захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч
Данзангийн Даянбилгүүний тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Данзангийн Даянбилгүүн
Төрсөн он: 1976 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: “БиДиСек” ХК, Гүйцэтгэх захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1984	1994
2	Европ хэлний дээд сургууль	Бизнесийн эдийн засагч	1994	1998
3	СЭЗДСургууль	Бизнесийн удирдлага, магистр	2006	2011

3. Ажлын туршлага

1994-1995 онд Эдийн тэнгэр банк, оператор-нягтлан бодогч
1995-1997 онд Улсын их хурлын тамгын газар, гишүүний орон тооны ажилтан
1997-1999 онд БиДиСек ХК, салбарын менежер
1999 оноос БиДиСек ХК, гүйцэтгэх захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч
Бүрэнмэндийн Лхагвадоржийн тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Бүрэнмэндийн Лхагвадорж

Төрсөн он: 1976 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: БиДиСек ҮЦК ХК, тэргүүн дэд захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1983	1993
2	ШУТИС	Нефтийн инженер	1993	1997

3. Ажлын туршлага

1997 оноос БиДиСек ҮЦК ХК, тэргүүн дэд захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч
Шараагийн Шинэбаярын тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Шараагийн Шинэбаяр

Төрсөн он: 1979 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: “ БиДиСек ҮЦК ” ХК-нд менежер



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд		
2	Сэрүүлэг дээд сургууль	Бизнесийн удирдлага	2001	2005

3. Ажлын туршлага

2009 оноос “ БиДиСек “ ХК-ны хөрөнгө оруулалтын албанд менежер

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч
Жаргалсайханы Энхтулгын тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Жаргалсайханы Энхтулга

Төрсөн он: 1987 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил:

“ Лайф ис гүүд монголиа ” ХХК, нягтлан бодогч



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын 1-р сургууль	Бүрэн дунд	1995	2005
2	Санхүү Эдийн Засгийн дээд сургууль	Бизнесийн удирдлага	2005	2010

3. Ажлын туршлага

2011 онд МҮХАҮТанхим, НБТЗГазар туслах ажилтан

2014-2017 онд “ Лайф ис гүүд монголиа ” ХХК, худалдан авалтын зөвлөх

2017 оноос “ Лайф ис гүүд монголиа ” ХХК, нягтлан бодогч

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч
Алтангэрэлийн Цэнгэлийн тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Алтангэрэлийн Цэнгэл

Төрсөн он: 1985 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: хувиараа



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	ШУТИСургуулийн лицей	Бүрэн дунд	2001	2003
2	ИрГУПС	Дээд	2003	2008
3	Нанкай	магистр	2014	2015
4	Удирдлагийн академи	магистр	2012	2018

3. Ажлын туршлага

2008-2013 онд Улаанбаатар төмөр зам,

2013-2015 онд Ти Ай ложистик ХХК, дэд

2015-2017 онд Рэйлнет ХХК, дэд

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч
Чулуунбаатарын Оргилын тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Чулуунбаатарын Оргил
Төрсөн он: 1987 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил:



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын 1-р сургууль	Бүрэн дунд	1995	2005
2	Хан-Уул Дээд сургууль	Бизнесийн удирдлага	2005	2010
3	Хан-Уул Дээд сургууль	Программ хангамж	2005	2011
4	Chinese Culture University	Мэдээллийн удирдлагын систем, Магистр	2012	2013

3. Ажлын туршлага

2015-2016 онд ҮАБЗөвлөл-ССХ-д мэргэжилтэн,
2017-2019 онд БНЭУлсын Элчин сайдын яам маркетингийн албаны дарга
2019 оноос МГТБҮ ТӨХХГ ГХХ-ийн дарга

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч
Хасгийн Бат-Эрдэнийн тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Хасгийн Бат-Эрдэнэ
Төрсөн он: 1980 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: “Интерсорс инк” ХХК захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	МУИС	Улс төр судлаач, Нийгэм судлалын багш	2001	2005

3. Ажлын туршлага


2007-2010 онд Эс Би Ложистикс ХХК-нд тээврийн менежер
2011-2014 онд Гранд ложистикс ХХК-нд гүйцэтгэх захирал
2014 оноос одоог хүртэл Интерсорс инк ХХК-ны захирал



Хэлэлцэх асуудал 6. ТУЗ-ийн 2021 оны цалин урамшууллын төсөв

ТУЗ-ийн цалин урамшууллын төсөв

	Зардлын нэр	Нэгжийн зардал	Зардлын дүн / төгрөг /
1	ТУЗ -ын гишүүдийн цалин	-	-
2	ТУЗ -ын нарийн бичгийн цалин	240,000*4	960,000
3	Зөвлөх үйлчилгээний хөлс	1,000,000	1,000,000
4	ТУЗ -ын хурлын зардал	1,000,000	1,000,000
5	Томилолтын зардал	1,000,000	1,000,000
6	Бичиг хэргийн зардал	100,000	100,000
7	Бусад /ХЭХ-ын зар гаргах /	500,000	500,000
	Дүн		4,560,000



**Хэлэлцэх асуудал 7.
Ногдол ашгийн талаар
гаргасан шийдвэр**

Ногдол ашиг



Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021.07.16.

№ 01

Борхойн тал

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай Монгол улсын хуулийн 46-р зүйлийн 46.1, 46.5, 46.14 дэх заалт, Компанийн дүрмийн 4-р зүйлийн 4.4 дэх заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс эчнээ санал хураалтаар авсан саналын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Э-Транс Ложистикс" ХК-ны 2020 оны санхүүгийн үйл ажиллагааны цэвэр ашгийн 85 хувь буюу нэгж хувьцаанд 5 төгрөгөөр 46,200,000 хувьцаанд нийт 231,000,000.00 төгрөгний ногдол ашиг хуваарилахаар тогтсугай.

2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэх өдрөөр тасалбар болгосугай.

3. Ногдол ашиг хуваарилах ажлыг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХХК-иар дамжуулан зохион байгуулж 2021 оны 07 сарын 30-ны дотор тухайн компанийн дансанд шилжүүлж дуусгах ба ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э.БАТБОЛД